

ШИНЖЭЭЧ СОНГОХ УРИЛГА

1. Төв аймаг дахь Төрийн аудитын газар нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/82 дугаар тушаалаар батлагдсан “Шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-ыг тус тус үндэслэн Багц 2, Багц 3, Багц 4-ийн жагсаалтад орсон шалгагдагч этгээдийн 2021 оны санхүүгийн тайланд хийх аудитыг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх аудитын хуулийн этгээдийг сонгон шалгаруулах тул Үндэсний аудитын газрын хураангуй жагсаалтад орсон аудитын хуулийн этгээдүүдийг холбогдох ажлын багцуудад саналаа ирүүлэхийг урьж байна.

Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах багцын жагсаалт, ажлын даалгаврыг үндэслэн Саналын жишиг баримт бичгийг маягтын дагуу бүрдүүлж ирүүлнэ. Үүнд:

Бүлэг 1. Урилга

Бүлэг 2. Ажлын даалгавар

Бүлэг 3. Саналын жишиг бичиг баримт

Бүлэг 4. Гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл

2. Саналын жишиг баримт бичгийг Төв аймаг дахь Төрийн аудитын газраас цахимаар болон цаасаар ирж худалдан авна уу.

3. Нэмэлт мэдээллийг авах хүсэлтийг санал ирүүлэх хугацаанаас ажлын 2 хоногийн өмнө албан бичгээр ирүүлнэ.

4. Саналаа битүүмжлэн дор хаягаар 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 15 цаг 00 минутын дотор цаасаар болон цахим хэлбэрээр ирүүлнэ үү.

5. Хугацаа хоцроосон мэдүүлгийг хүлээн авахгүй болно.

Хаяг: Төв аймаг, Зуунмод сум, Төр захиргааны 2-р байр, 102 тоот
Холбоо барих албан тушаалтны нэр: Аудитын менежер О.Амаржаргал
Утас: 88039862

ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР